



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 07 өдөр

Дугаар A/143

Мөрөн сум

Газрын дуудлага худалдаа зохион
байгуулах комисс томилох тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, “Газрын тухай” хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын /газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам/ 1 дүгээр хавсралтын 9.1, 9.2-д заасныг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын 2024 оны 09 дугаар сарын 09-ний өдрийн А/126 тоот захирамжаар зарласан газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга	Б.Мягмаржав	Засаг даргын Орлогч
Дуудлага худалдааны Хөтлөгч	Г.Банзрагч	Газрын даамлыг түр орлон гүйцэтгэгч
Тэмдэглэл хөтлөгч	Г.Энхцэцэг	Архив, бичиг хэргийн эрхлэгч

2. Газрын дуудлага худалдааг зохих хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, ялагчтай гэрээ байгуулж хуулийн хугацаанд орлогыг төсөвт хуримтлуулж иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын даамлыг түр орлон гүйцэтгэгч /Г.Банзрагч/-д даалгасугай.

ДАРГА

Ц.БАТЦООЖ